

“ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГЫГ ЧАДАВХЖУУЛАХ ЗАМААР
ЦАХИМ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ”
(DICE) ТӨСӨЛ



МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН
ТЭГШ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ЗАМЫН
ЗУРАГЛАЛ

Улаанбаатар
2024 он

ӨМНӨТГӨЛ

Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх нь” (DICE) төслийг Пипл ин Нийд (ПИН) ОУТББ Фаро Фаундэйшн ТББ болон Цахим хөгжил, Инновац, Харилцаа холбооны Яам (ЦХИХХЯ)-тай хамтран хэрэгжүүлж байна.

Энэхүү “Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглал”-ыг (цаашид ‘Замын зураглал’ гэх) DICE төслийн хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, УИХ, Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хийсэн судалгаа, шинжилгээний үр дүн, гол оролцогч талуудын өгсөн үнэтэй санал зөвлөмжид үндэслэн боловсруулав.

Замын зураглал боловсруулах судалгааг дараах бүрэлдэхүүнээс бүрдсэн үндэсний зөвлөх баг гүйцэтгэсэн:

- ✓ Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон Улсын судалгааны төв (ДГХБО-ын ОУСТ)-ийн Гүйцэтгэх захирал Д.Дөлгөөн
- ✓ ДГХБО-ын ОУСТ-ийн Ахлах зөвлөх Л.Ариунаа
- ✓ ДГХБО-ын ОУСТ-ийн Хууль зүйн зөвлөх Б.Мөнхтогтох

Мөн дараах ПИН ОУТББ-ын ажилтнууд замын зураглалыг боловсруулахад хувь нэмрээ оруулсан:

- ✓ ПИН ОУТББ-ын Хөтөлбөрийн захирал Д.Амаржаргал
- ✓ ПИН ОУТББ-ын Төслийн менежер Д.Түвшинтөгс
- ✓ ПИН ОУТББ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний менежер З.Тогтохмаа
- ✓ ПИН ОУТББ-ын Иргэний нийгмийн зөвлөх Жапаридзе Тинатин

Энэхүү замын зураглалд тусгагдсан судалгааны үр дүн, санал, зөвлөмж нь ПИН ОУТББ-ын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлэхгүй болно.



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ



Co-funded by
the European Union



FARO Foundation

Энэхүү замын зураглалыг Европын Холбооны санхүүжилтээр бүтээсэн бөгөөд бүтээлийн агуулга зөвхөн тус байгууллагын ажиглалт, дүгнэлтийг илэрхийлж байгаа ба Европын Холбооны албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.

ТОВЧИЛСОН ҮГС

БЯ	Боловсролын яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ДГХБО-ын ОУСТ	Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв
ЕХ	Европын холбоо
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ПИН	Пипл Ин Нийд
ТББ	Төрийн бүс байгууллага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ОУТББ	Олон улсын төрийн бүс байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Цахим засаглалын хөгжлийн индекс ба дэд индексүүд.....	5
Зураг 2. Цахим оролцооны индекс.....	5
Зураг 3. Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалын тойм	12
Хүснэгт 1. Цахим шилжилтээс хоцрох буюу орхигдох эрсдэл өндөртэй зорилтот бүлгүүд.....	7
Хүснэгт 2. Оролцогч талуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлгийн гол үр дүнгүүд	8
Хүснэгт 3. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын голлох хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд	10
Хүснэгт 4. Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалын үйл ажиллагааны төлөвлөгөө	16
Хүснэгт 5. Цахим шилжилтийн хүрээнд ОУБ-уудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд	27

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Пипл ин Нийд (ПИН) нь 2009 оноос хойш Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа 31 гаруй оронд салбартай Олон Улсын Төрийн бус байгууллага (ОУТББ) юм. ПИН нь Монгол Улсын иргэний нийгмийн байгууллагуудыг хүчирхэг, хүний эрхийг дээдэлсэн, өөрчлөлт, тэгш боломжийг хангах нийгмийн хөдөлгөгч хүч болоход нь туслах зорилготой үйл ажиллагаа явуулж байна.

ПИН ОУТББ, Фаро Фаундэйшн болон Цахим хөгжил, Инновац, Харилцаа холбооны Яам хамтран Европын холбооны санхүүжилттэй “Иргэний нийгмийн байгууллага (ИНБ)-ыг чадавхжуулах замаар цахим оролцоог нэмэгдүүлэх (Digital Inclusion through Civil society organizations Empowerment – DICE) төслийг 2023 оноос хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд “Цахим шилжилтийн тэгш оролцоог хангах нөлөөллийн ажлын замын зураглал” боловсруулах ажлыг Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв зөвлөх үйлчилгээний гэрээний хүрээнд гүйцэтгэж, үр дүнг энэхүү тайлангаар танилцуулав.

Цахим шилжилтийн тэгш оролцоог хангах нөлөөллийн ажлын замын зураглал боловсруулахын тулд Монгол Улсын хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал¹, цахим шилжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн баримт бичиг², цахим шилжилттэй холбоотой олон улсын судалгаа, индекс³ зэргийг судлан дүн шинжилгээ хийсэн. Үүнээс гадна Глоб интернейшнл, АЛЛ4Е ИНБ, Цахим хөгжил, инноваци, харилцаа, холбооны яам (ЦХИХХЯ), Боловсролын яам (БЯ), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ГБХНХЯ), И-Монгол академи зэрэг төрийн байгууллага болон хувийн хэвшлийн төлөөлөл АйСиТи группын удирдлагатай ганцаарчилсан ярилцлага хийж, зорилтот бүлгийн 11 төлөөллийг хамруулсан фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Энэхүү ажлын үр дүнд боловсруулсан замын зураглалд үндсэн 3 зорилтыг дэвшүүлэв.

- **Зорилт 1:** Төрийн зүгээс цахим шилжилтийн тэгш оролцоог хангасан бодлого, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- **Зорилт 2:** Төр, хувийн хэвшил, ИНБ-уудын хамтын оролцоог идэвхжүүлж, тэгш оролцох үр ашигтай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- **Зорилт 3:** Цахим шилжилттэй холбоотой бодлого, хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулахад ИНБ-ууд идэвхтэй оролцох, нөлөөлөх чадавхыг сайжруулан, зорилтот бүлгийн иргэдийн оролцоог хангах, төлөөлөх замаар аливаа бодлого, шийдвэр, хууль эрх зүйн баримт бичигт тэдний эрх ашиг, сонирхлыг тусгаснаар зорилтот бүлгийн иргэдийн тэгш оролцоо хангагдана.

Цахим шилжилтийн тэгш оролцоог хангах нөлөөллийн ажлын замын зураглалын зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх зарим ажлын саналыг тодорхой хугацаатай нь хамт боловсруулсан ба хэрэгжүүлж буй ажлуудын талаар мэдээлэх, үр дүнг олон нийтэд түгээн таниулах, болон хяналт шинжилгээ, үнэлгээний ажлуудыг тусгаж, шаардагдах нөөц, боломжит оролцогч талуудыг тодорхойлов.

¹ Алсын хараа – 2050, Шинэ сэргэлтийн бодлого, Салбаруудын зорилтот хөтөлбөр, г.м.

² Цахим үндэстэн баримтлах чиглэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, 109 хуулийн нэмэлт, өөрчлөлт, г.м.

³ Нэгдсэн Үндэстний байгууллага, Дэлхийн банк, Олон улсын цахилгаан холбооны байгууллага зэргийн судалгаа.

ҮНДЭСЛЭЛ

Цахим шилжилт, хөгжлийн үзүүлэлт

Монгол Улс 2024 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг “Цахим засаглалын тайлан”-д дурдсанаар Цахим засаглалын хөгжлийн индексээр 193 орноос 46-р байр, цахим оролцооны индексээр 37-р байрт тус тус орсон байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад цахим засаглалын хөгжлийн индексээр 28 байр, цахим оролцооны индексээр 20 байр урагшилсан дэвшлийг үзүүлсэн байна. Цахим засаглалын хөгжлийн индекс нь Цахим засаглалын судалгааны аргачлалын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд гурван дэд индексээс бүрддэг⁴.

Зураг 1. Цахим засаглалын хөгжлийн индекс ба дэд индексүүд




Монгол Улс нь далайд гарцгүй, хөгжиж буй орны хувьд дэлхийн цахим хөгжлөөс хоцрохгүй байх, цахим оролцоог нэмэгдүүлэх, цахим үр чадварыг дээшлүүлэх шаардлагатай хэвээр байна. Далайд гарцгүй, хөгжиж буй 32 орноос Казахстан Улс цахим засаглалын хөгжлийн индексээр 26-р байр эзэлж байгаа ба Казахстаны цахим засаглалын платформ нь 1000 гаруй онлайн үйлчилгээ үзүүлж байна. Улсын төсвийн талаарх мэдээллийг онлайнаар авах, цахим зөвшөөрөл, ухаалаг өгөгдлийн Укимет систем⁵ зэрэг санаачилга нь төрийн үйлчилгээг ил тод болгож байна.

Казахстан Улсын 2023-2029 онд тавьсан цахим шилжилтийн зорилт нь төрийн үйлчилгээг дээшлүүлэх, төрийн захиргааны шилжилтийг хурдасгаж, эдийн засгийн салбарыг хөгжүүлэхэд түлхэц өгөхөөр тодорхойлогджээ. Ингэхдээ технологийн давуу талыг цахим үр чадвартай, тэгш оролцоог хангасан нийгэм бий болгоход ашиглаж иргэд-төвтэй үйлчилгээ хүргэхэд түлхүү анхаарч байна.

Казахстан Улс нь цахим дэд бүтцийг хөгжүүлэхэд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийж, хиймэл оюун ухаан, блокчейн, юмсын интернэт⁶ зэрэг шинэ технологийг төрийн захиргааны шинэчлэл болон төрийн үйлчилгээг хүргэхэд ашиглаж байна. Казахстан Улс үндэсний стратегидаа мэдээлэл холбооны технологийн хөгжил, цахим бичиг үсгийн боловсролыг нэн тэргүүнд тавьсан нь цахимжуулалтыг хурдасгаж байна⁷. Цахим засаглалын судалгааны хүрээнд цахим оролцооны индексийг мөн адил тодорхойлдог.

Зураг 2. Цахим оролцооны индекс



⁴ <https://publicadministration.un.org/egovkb/en-us/Data/Country-Information/id/113-Mongolia>

⁵ НҮБ-ын ЭЗНГ, 2024, хууд. 112

⁶ Англиар: “Internet of Things, IoT” нь интернетэд холбогдсон төхөөрөмжүүдийн сүлжээ юм. Энэ төхөөрөмжүүд нь өөр хоорондоо мэдээлэл солилцох, удирдах, автоматжуулсан үйлдлүүдийг хийх боломжтой байдаг.

⁷ НҮБ-ын ЭЗНГ, 2024, хууд. 110

Монгол Улс нь 2024 онд цахим оролцооны индексээр 37-р байранд орж (0.7808) өндөр⁸ гэсэн 4 бүлэгт багтаж байна. Монгол Улсын онлайн үйлчилгээний индекс (0.7808) нь дэлхийд тэргүүлэгч Эстони Улс (1.0000) болон далайд гарцгүй орнуудаас Казахстан (0.9390)-тай харьцуулахад нэлээд доогуур үнэлгээтэй байна. Түүнчлэн Монгол Улс нь цахим мэдээллийн индексээр 0.3333, цахим зөвлөлдөөний индексээр 0.5, харин цахим шийдвэр гаргалтын индексээр 0.94 оноотой байна.

Цахим засаглалын судалгааны хүрээнд тодорхойлдог өөр нэг индекс нь орон нутгийн онлайн үйлчилгээний индекс юм. Орон нутгийн онлайн үйлчилгээний индексийг 2018 оноос боловсруулж Цахим засаглалын судалгаанд оролцуулсан байна⁹. Орон нутгийн онлайн үйлчилгээний индекс нь 5 бүлгийн 86 үзүүлэлтээс бүрддэг цахим үнэлгээний аргачлал бөгөөд хариултууд нь “1” (орон нутгийн төрийн байгууллагын цахим хуудас дээр байсан) эсвэл “0” (цахим хуудас дээр мэдээлэл байгаагүй эсвэл судлаачид мэдээлэл олж чадаагүй) гэсэн утгатай байдаг.

Цахим засаглалын судалгаанд 2022 оноос “Холимог дижитал нийгэмд хэнийг ч орхигдуулахгүй байх” бүлгийг нэмсэн. Энэ нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын аль алинд нь хамааралтай бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөлөөс тогтвортой хөгжлийг дэмжих үр өгөөжтэй засаглалын 11 зарчмын нэгээр балтлагдсан болно.

Эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цагаач, дүрвэгсэд болон бусад алслагдсан бүлгийн иргэдийг орчин үеийн холимог цахим нийгэмд орхигдуулахгүй байхын тулд цахим засаглалын тайланд “Хэнийг ч орхигдуулахгүй байх”¹⁰ зарчмыг багтаасан бөгөөд уг зарчим нь өгөгдөл, загвар, хүргэлт гэсэн үзүүлэлтүүдээр хэмжигддэг.

ПИН ОУТББ [DICE төслийн сүүр судалгааг](#) 2024 онд ИНБ-уудын ажилтнууд, цахим бодлого болон түүний хэрэгжилтийг хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллагуудын төлөөлөл зэрэг нийт 127 оролцогчийг хамруулан зохион байгуулсан байна. Судалгааны гол үр дүнд ИНБ-ууд нь:

- Цахим үр чадвар, цахим оролцоо, цахим шилжилтын талаар нэгдсэн ойлголт байхгүй;
- ИБН-ын ажилтнуудын цахим үр чадвар түвшинг дээшлүүлэх;
- ИБН-ын Зорилтот бүлгийн иргэдийн цахим үр чадвар, цахим оролцоо хангалтгүй;
- ИБН-ын үйл ажиллагааны цахимжилт хангалтгүй;
- ИНБ-ууд төрийн аливаа үйл ажиллагаа, бодлогод нөлөөлөх, бодлого боловсруулахад оролцох, хяналт тавих чиглэлээр ажиллах нь хязгаарлагдмал байна гэсэн дүгнэлт гарсан.

Өөрөөр хэлбэл зорилтот бүлгийн иргэдийн цахим үр чадвар, цахим оролцоо хангалтгүй байгаа гэсэн судалгааны үр дүн гарсан.

Иймд зорилтот бүлгийн иргэд ялангуяа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, эмэгтэйчүүд, малчид, ажил эрхлээгүй залуучууд зэрэгт чиглэсэн бодлого боловсруулж, тэдний цахим оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн тодорхой хөтөлбөр, төсөл, ажлыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Хот, хөдөөгийн цахим зааг, ялгааг арилгахын тулд цахим дэд бүтцийг сайжруулах, цахим засаглал, цахим үр чадварыг дэмжих үйл ажиллагааг улам үр дүнтэй болгох шаардлагатай байна.

⁸ Цахим оролцооны индексийг Бага, Дунд, Өндөр, Маш өндөр гэсэн 4 бүлэгт хуваадаг.

⁹ НҮБ-ын ЭЗНГ, 2022, хууд. 182

¹⁰ Англиар: Leaving no one behind (LNOB)

Иргэний нийгмийн байгууллагуудын цахим шилжилт дэх оролцоо

Монгол Улсад 2023 оны байдлаар 31,130 ТББ байгаагийн 80 хувь нь нийслэл хотод, 20 хувь нь хөдөө орон нутагт бүртгэлтэй байна¹¹. Гэвч эдгээр ИНБ-ын төрөл, үйл ажиллагааны чиглэлийн талаар дэлгэрэнгүй, нарийвчилсан тоон мэдээлэл одоогоор байхгүй байна. Учир нь ИНБ-уудыг хуулийн этгээдийн улсын бүртгэлд салбар, үйл ажиллагааны чиглэлээр нь ангилахын оронд “бусад” гэсэн ангилалд багтаасан байдаг.

НҮБ-аас 1992 онд баталсан тунхаглал, конвенц, удирдамжид үндэслэн Монгол Улс, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027 баримт бичигт тодорхойлсон зорилтот 10 бүлгийн¹² иргэдийн эрх ашгийг хамгаалж, тэдэнд зориулсан үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын талаарх нэгдсэн мэдээлэл мөн адил байхгүй байна. Монгол Улсын 2023 оны Статистикийн эмхэтгэлд зорилтот бүлгийн иргэдийн тоог дараах байдлаар мэдээлжээ.

Хүснэгт 1. Цахим шилжилтээс хоцрох буюу орхигдох эрсдэл өндөртэй зорилтот бүлгүүд

#	Зорилтот бүлэг	Нийт (2023 оны байдлаар)
1	Хүүхэд, өсвөр үеийнхэн	1,360,055
2	Хөдөөгийн орлого багатай иргэд, малчид	298,338
3	Угсаатны цөөнх	120,000
4	Ажилгүй, үр чадваргүй залуус	69,000
5	Охид, эмэгтэйчүүд	1,786,500
6	Оролцооны бэрхшээлтэй хүмүүс	111,228
7	Ахмад настнууд	455,166
8	Дотоодын шилжин суурьшигчид болон Хот, суурин газрын орлого багатай иргэд	56,152 албан ёсны тоон мэдээлэл байхгүй
9	Бэлгийн цөөнх	албан ёсны тоон мэдээлэл байхгүй
10	Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид	албан ёсны тоон мэдээлэл байхгүй

Замын зураглалд дээрх зорилтот бүлгийн иргэд болон тэдгээрийн төлөөлж буй ИНБ-ын санал, бодлыг тусгах зорилгоор 2024 оны 10-р сард Глоб интернейшнл, Алл4Е зэрэг ИНБ-ын төлөөлөлтэй ярилцлага хийж, зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээ үзүүлж, үйл ажиллагаа явуулдаг 11 ИНБ-ын төлөөллийг хамруулсан фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Түүнчлэн, ЦХИХХЯ, БЯ, ГБХНХЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, төрөөс зорилтот бүлгийн иргэдийн цахим шилжилтэд тэгш оролцоог хангах чиглэлээр баримталж буй бодлого, дэвшүүлж буй зорилтууд, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг тодруулах зорилгоор уулзалтууд зохион байгуулсан. Доорх хүснэгтэд оролцогч талуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлага болон бүлгийн хэлэлцүүлгийн гол үр дүнг хураангуйлан харуулав.

¹¹ ПИН, Бодлогын хэлэлцүүлэгт иргэний нийгмийн байгууллагын оролцоо, 2023, х.5

¹² Монгол Улс, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ 2023-2027, 2022, х.18

Оролцогч тал	Мэдээлэл цуглуулсан арга	Гол үр дүн
Зорилтот бүлэгт чиглэсэн үйлчилгээ үзүүлж үйл ажиллагаа явуулдаг 11 ИНБ-ын төлөөлөл	Фокус бүлгийн хэлэлцүүлэг	- Зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ИНБ-уудын цахим шилжилт дэх оролцоо хангалтгүй - Цахим шилжилтийн талаарх мэдээлэл, ойлголт, мэдлэг дутмаг - Бодлого, хууль эрх зүйн (ялангуяа шинээр боловсруулж буй хууль, журам, бодлогын) талаар мэдээлэл хангалтгүй, төрийн бус байгууллагуудын цахим үр чадвар зохих хэмжээнд хүрээгүй - ИНБ-уудын хамтын ажиллагаа сул - Зорилтот бүлгүүд хууль, бодлогын төсөлд санал өгдөг ч тэдгээрийг тусгах, эргэх холбоо хангах асуудал сул хэвээр байна. - Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг бүлгүүдийн цахим шилжилтийн талаарх мэдээлэл дутмаг байдал, техник төхөөрөмж, үр чадварын дутагдал нь тэднийг цахим хуваагдалд өртөхөд хүргэж байна. - Сонсголын бэрхшээлтэй иргэдийн дохионы хэлний стандарт, дохионы орчуулгын хууль зэрэг тусгай хэрэгцээт зохицуулалт, мөн Web Content Accessibility Guidelines (WCAG)-д нийцсэн апп хөгжүүлэлт дутагдаж байна. - Төрийн цахим системүүд хүртээмж муутай, үнэлгээ хийлгэхгүйгээр хэрэгжүүлдэг нь цаг хугацаа, санхүүгийн үр ашиггүй байдлыг бий болгож байна. - ИНБ-уудыг чадавхжуулах, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт явуулах, цахим боломжийг ашиглан санал авах үйл явцыг сайжруулах, үндэсний нэгдсэн мэдээллийн платформ бий болгох шаардлагатай байна. - Цахим шилжилтийн тэгш оролцоог хангахын тулд ажлын хэсэгт ИНБ-ыг оролцуулах, сургалт зохион байгуулах, И-Монголиаг хялбаршуулах, мөн хувийн хэвшилтэй хамтран хөгжүүлэлт хийх нь чухал байна. - Нөөц, чадвар, түршлагын үр дүнтэй хуваарилалтыг хангах үүднээс ИНБ-уудын зураглал гаргаж, төр, ИНБ, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. - Ахмадууд, ХБИ, асаргаа хийдэг ээжүүд зэрэг зорилтот бүлэгт зориулсан цахим үр чадварыг хөгжүүлэх сургалт явуулах, технологийн дэмжлэг үзүүлэх замаар тэдний цахим шилжилтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
ЦХИХХЯ, ГБХНХЯ-ны холбогдох албан тушаалтнууд	Ганцаарчилсан ярилцлага	- Цахим шилжилтийн бодлого тодорхойгүй байна. Иймд, хамгийн түгээмэл, нийтэд хүртээмжтэй “И-Монголиа” хөтөлбөрийг дэмжих, цаашид “Ухаалаг Улаанбаатар”-тай төстэй стратегийн концепц боловсруулах шаардлагатай байна. - Зорилтот бүлгийн иргэд болон ИНБ-уудын оролцоог хангахын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлөөр дамжуулан төрийн бодлого, үйл ажиллагаанд оролцуулах, тэдний хэрэгцээг тусгасан хүртээмжтэй сайтуудыг хөгжүүлэх шаардлагатай. - Төрийн цахим үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд хүртээмжтэй болгох, жишээлбэл, www.gov.mn сайтыг WCAG стандартад нийцүүлэн сайжруулсан шиг шийдлийг үргэлжлүүлэн нэвтрүүлэх хэрэгтэй. - Иргэдийн цахим үр чадварыг хөгжүүлэхэд Дэлхийн банк, АХБ, Жайка, НҮБ зэрэг байгууллагуудтай хамтран ажиллах, хэмжих аргачлал боловсруулах, мөн сургалтын өрөө бүхий инновацийн төвүүдийг өргөжүүлэх шаардлагатай. - Цахим шилжилтийн хүрээнд хэрэглэгчдийг бэлтгэх, дата бэлтгэх, боловсролын шинэчлэл хийх, мөн хиймэл оюун ухааныг үр дүнтэй ашиглах замаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй.
АйСиТи группийн удирдлага	Ганцаарчилсан ярилцлага	Мэдээллийн технологийн салбарт хөгжүүлж буй програм хангамж, мэдээллийн системд зорилтот бүлгийн иргэдийн ашиглах боломж, хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн ажил одоохондоо байхгүй байна.

Оролцогч тал	Мэдээлэл цуглуулсан арга	Гол үр дүн
ГБХНХ-ын яамны ажилтан	Ганцаарчилсан ярилцлага	- Зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулахад тэдний оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай. - Төрийн байгууллагын дэргэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах зөвлөлүүд ажиллаж байгаа ч бодлого хэрэгжилтэд илүү үр дүнтэй хяналт хэрэгтэй. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд зорилтот бүлгийн төлөөллийг тогтмол оролцуулах нь чухал байна. - Цахим шилжилттэй уялдуулан ХБИ-ийн үр чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр болон тусгай боловсролд анхаарах ажил дутагдаж байна. Сургагч багш болон хүртээмжтэй цахим орчин бүрдүүлэхэд төр, хувийн хэвшил, ИНБ-үүдйн хамтын ажиллагаа шаардлагатай. - Гар утасны аппликейшн болон вэб сайтуудын хүртээмжийг сайжруулж, ХБИ-ийг цахим үйлчилгээнд хамруулахад анхаарах шаардлагатай. И-Монголиа апп харааны бэрхшээлтэй иргэдэд тохиромжгүй, мөн аймаг бүрт дохионы хэлмэрч бэлтгэх хэрэгцээ бий. - ХБИ-ийг чадавхжуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтвортой санхүүжилт, хөтөлбөр хэрэгтэй байна. Жайка-ийн төслөөс гарсан сургалт, дадлагажуулалтын үр дүнг өргөжүүлж, илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх нь чухал.
БЯ-ны албан тушаалтнууд	Ганцаарчилсан ярилцлага	2023 оны боловсролын багц хуульд ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах шаардлага, зохицуулалтыг тусгаж, тэдэнд зориулсан дэмжлэг үзүүлэх бодлого хэрэгжүүлэх орчин бүрдэж байна. - Тэгш оролцоог хангах чиглэлээр МУБИС, ЕБС-ийн багш нарыг сургах, аймгийн боловсролын газарт дэмжих зөвлөлүүд байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа ч боловсон хүчний дутагдалтай байна. - Зорилтот бүлгийн иргэдийн цахим үр чадварыг дээшлүүлэхэд эрх зүйн мэдээлэл хүргэх, төсөл боловсруулалт, бичиг баримт боловсруулах зэрэг чадварыг хөгжүүлэх сургалт нэн шаардлагатай байна. - Төрийн байгууллагуудын ажилтнуудад зорилтот бүлгийн иргэдтэй ажиллах анхан шатны мэдлэг олгох, тэдний хэрэгцээнд нийцсэн аппликейшн, сургалтуудыг хөгжүүлэх замаар хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.
Глоб интернейшнл, Алл4Е зэрэг ИНБ-ын төлөөлөл	Ганцаарчилсан ярилцлага	- Цахим шилжилттэй холбоотой хууль эрх зүйн баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хянахад ИНБ болон зорилтот бүлгийн иргэдийн оролцоо хангалттай биш бөгөөд санал авах механизмүүдэд бэрхшээлүүд үүсч байгаа. - Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах хууль, е-парламентын санал асуулга зэрэг хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн үйл ажиллагааг хангалттай үр дүнтэй болгож чадахгүй байгаа нь бодлого боловсруулахад хүндрэл үүсгэдэг. - ИНБ-үүдйн цахим үр чадвар хангалтгүй бөгөөд цахим харилцаа, дижитал бичиг үсэг, үр чадвар дээшлүүлэх шаардлага тулгарч байна, мөн орон нутгийн байгууллагуудын цахим чадвар ч дутагдалтай байна. - ИНБ-үүд төртэй хамтран ажиллахад эрх зүйн орчны дутмаг байдал, санхүүжилтийн асуудал, мэдээллийн хүртээмж болон ойлгомжтой байдал зэрэг олон бэрхшээл тулгарч байна. - ИНБ-үүдйн үр чадварыг нэмэгдүүлэх, хууль эрх зүйн орчныг шинэчлэх, хөдөө орон нутагт цахим үр чадварыг дээшлүүлэх замаар зорилтот бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.
И-Монгол академийн удирдлага	Ганцаарчилсан ярилцлага	- ДАН танилтын систем болон ХУР систем нь олон байгууллагуудтай холбогдож, иргэдийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн бөгөөд 51 сая хүсэлт хүлээн авч 302.2 сая ам.доллар хэмнэсэн. - Харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан цахим технологийн хэрэглээг сайжруулах, сургалт зохион байгуулж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. - Цахим шилжилттэй холбоотой сургалтуудыг явуулах, технологи, тоног төхөөрөмжөөр хангах нь иргэний нийгмийн тэгш оролцоог нэмэгдүүлэхэд чухал юм.

Хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын мэдээлэл харилцаа холбооны салбарт 2021 он хүртэл цөөн тооны хууль хүчин төгөлдөр мөрдөгддөг байв. Сүүлийн 3 жилийн хугацаанд доорх хүснэгтэд харуулсан хууль, бодлогын баримт бичгүүдийг баталж эдгээрийн хэрэгжилтийг хангах 30 гаруй журмыг баталсан ч тэгш оролцоог хангахтай холбоотой асуудлыг орхигдуулсан байна.

Хүснэгт 3. Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын голлох хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд

Баталсан огноо	Хууль, бодлогын баримт бичгүүд
Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын А/24 тушаал 2022/05/18	“Цахим үндэстэн” - баримтлах 6 стратегийн чиглэл
Монгол Улсын Их хурал 2021/12/17	Багц хууль : - Цахим гарын үсгийн тухай хууль - Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль - Кибер аюулгүй байдлын тухай хууль - Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль
Монгол Улсын Их хурал 2024/05/14	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль

Үүнээс гадна, салбарын сайдын баталсан “Цахим үндэстэн” – баримтлах 6 стратеги нь хэрэгжилтийн түвшинд хууль, эрх зүйн зөрчлийг үүсгэсэн байна. Үүнд:

- 1) Цахим шилжилтийн нэгдсэн стратеги тодорхой бус, салбар дундын зохицуулалтыг хэрхэн хангах талаар уялдаа холбоо дутмаг, нэр томъёо, ойлголтууд хоорондоо зөрүүтэй.
- 2) Цахим шилжилтийн хүрээнд ИНБ-уудын оролцоог салбар хооронд уялдуулсан зорилт, арга хэмжээнүүдийг бодлогын баримт бичгүүдэд тусгаагүй.
- 3) Цахим шилжилтийн урт хугацааны бодлого уялдаа муутай, дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдийг батлаагүй, богино хугацааны нэгдсэн стратеги тодорхойгүй, салбар дундын зохицуулалтгүй байдал нь бодлогын тодорхойгүй орчин, нөхцөлийг бий болгож байна.

Иймд дараах асуудлуудыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага байна. Үүнд:

- 1) Товч бөгөөд тодорхой зохицуулалт бүхий стратеги боловсруулах хэрэгтэй бөгөөд үүнд дижитал шилжилттэй холбоотой өмнө нь баталсан үндсэн болон багц хуулиудын нийцлийг хянах, зорилтот бүлгүүдийн эрх зөрчигдөж байгаа эсэхийг шалгах, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнг гүнзгий судлах шаардлагатай. Түүнчлэн цахим шилжилтийн нэр томъёо, ойлголтууд (ж.нь: цахим шилжилт, цахим үр чадвар, цахим оролцоо, цахим хуваагдал г.м)-ыг нутагшуулж, тэдгээрийг хууль тогтоомжид нэг утгаар хэрэглэх, мөн эдгээр ойлголтыг иргэдийн дунд нэгдсэн байдлаар түгээх шаардлагатай.
- 2) ИНБ-уудын оролцоог онцолсон чиглэл боловсруулах хэрэгтэй бөгөөд үүнд тодорхой зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтын ажиллагаа болон санал зөвлөмж авах механизмуудыг багтаах.
- 3) Нэгдмэл бөгөөд өөр хоорондоо уялдсан урт, дунд, болон богино хугацааны стратегийг боловсруулах хэрэгтэй бөгөөд ингэхдээ цахим шилжилтийн үе шат тус бүрд зориулсан тодорхой зорилтууд, хугацаа, хариуцах эзэнг тодорхойлж, үр дүнтэй хэрэгжилтийг хангах.

Түүнчлэн, ИНБ-уудын эрх зүйн орчинд томоохон шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага үүссэн байна. Одоогийн байдлаар “Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн дийлэнх заалтууд хуучирсан бөгөөд Иргэний хууль болон хуулийн этгээдийн ангилалд тодорхой бус, давхар утгатай заалтууд багтсан нь ноцтой саад тотгор учруулж байна. Эдгээр эрх зүйн хязгаарлалтууд нь ИНБ-уудын санхүүгийн болон үйл ажиллагааны тогтвортой бүтцийг бий болгох боломжийг хязгаарлаж, санхүүжилтэд хүрэх боломжийг хумьж, үр ашигтай менежментийн үйл ажиллагааг төвөгтэй болгож байна. Эрх зүйн тодорхой, шинэчлэгдсэн тодорхойлолтгүй байх нь ИНБ-уудын дотоод хөгжлийг удаашруулаад зогсохгүй, тэдний хууль ёсны байдал, хэлэлцээр хийх чадавхыг сүлрүүлж байна.

ИНБ-уудын эрх зүйн зохицуулалт хэсэгчилсэн, зарим талаараа хуучирсан байдалтай байгаа тул бодлого боловсруулах үйл явцад тэднийг тэгш оролцогчоор хүлээн зөвшөөрөхөд хүндрэл учруулдаг. Энэ тодорхойгүй байдал нь засгийн газрын яамдтай хамтран ажиллах, зорилтот бүлгүүдтэй хэлэлцээ хийх үед тэдний байр суурийг хязгаарлаж байна. Олон тохиолдолд төрийн байгууллагууд ИНБ-уудын санал зөвлөмж, оролцоог үл тоомсорлох эсвэл ач холбогдол багатай гэж үзэх хандлагатай байдаг нь тэдний дуу хоолойг улам бүр тусгаарлаж, зорилтот бүлгүүдийн хэрэгцээг төлөөлөн тэдний эрх ашгийг хамгаалах чадавхыг нь бууруулдаг.

Мөн эрх зүйн одоогийн зохицуулалт нь олон нийтэд ИНБ-уудын талаарх сөрөг хандлагыг бий болгоход нөлөөлж байна. Иргэдийн дунд ИНБ-уудыг найдвартай бус, үр нөлөөгүй гэж үзэх хандлага ажиглагддаг нь тэдний эрх зүйн байр суурийн тодорхой бус байдалтай нь холбоотой. Монгол Улсын Засгийн газар 2023 онд “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ыг батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулсан боловч энэ төслийг УИХ-д өргөн мэдүүлэх эсвэл батлах эсэх нь тодорхойгүй хэвээр байна. Эдгээр эрх зүйн шинэчлэлүүд бүрэн хэрэгжих хүртэл ИНБ-ууд санхүүгийн тогтвортой байдал, үйл ажиллагааны үр ашиг, олон нийтийн итгэлийг бий болгох чиглэлээр ноцтой сорилтуудтай тулгарсаар байх магадлалтай.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийг боловсруулахдаа олон нийтийн оролцоог хангах, санал авах, цахим хуудсанд байршуулах, ажлын хэсэгт оролцуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, мөн цахимаар санал өгөх (<https://d.parliament.mn>) үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр заасан. Энэ нь “Цахим үндэстэн” баримтлах чиглэл (2022-2027), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021), Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль (2021) зэрэг бодлого, хууль тогтоомжид тусгагдсан. Гэсэн хэдий ч эдгээр зохицуулалтыг ИНБ-ууд болон зорилтот бүлгийн иргэд бодитой ашиглаж хууль, бодлогын баримт бичиг боловсруулах үйл явцад хэрхэн оролцож байгаа, өгсөн санал нь хэрхэн тусгагдсан, эсвэл тусгагдаагүй тохиолдолд шалтгааныг тайлбарласан эргэх холбоо хангалтгүй байгааг зөвлөх баг онцолж байна. Иймд эргэх холбоог сайжруулах, оролцогч талуудын санал, оролцоог илүү үр дүнтэй болгох шаардлагатай байна.

Судалгаа шинжилгээ, дэлхийн улс орнуудын туршлага, ИНБ болон зорилтот бүлгийн иргэдтэй хийсэн ярилцлага, хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн санал дээр үндэслэн Монгол Улсын Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалыг боловсрууллаа. Энэхүү замын зураглал нь хууль эрх зүйн орчныг бэхжүүлэх бодлого боловсруулах, зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ИНБ болон зорилтот бүлгийн иргэдийн цахим үр чадварыг сайжруулах, мөн төр, хувийн хэвшил, ИНБ-уудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ТЭГШ ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫН ЗАМЫН ЗУРАГЛАЛ

Зураг 3. Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалын тойм



АЛСЫН ХАРАА:

Монгол Улсын хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад ИНБ-уудын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх замаар цахим шилжилтэд бүх нийтийн, тэр дундаа зорилтот бүлгийн тэгш оролцоог хангана.

ХЭТИЙН ТӨЛӨВ, АЧ ХОЛБОГДОЛ:

ИНБ-ууд нь эвлэлдэн нэгдэх, тэгш эрхтэй байх зарчмын хүрээнд цахим шилжилтээр дамжуулан өөрсдийн дотоод болон гадагшаа чиглэсэн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, төлөөлж буй зорилтот бүлгийн иргэдийн эрх, ашгийг хамгаалах, бодлогын нөлөөллийн ажлыг хийх цахим оролцоо, үр чадвар бий болно.

ЗОРИЛГО:

Замын зураглал нь цахим шилжилтийн бодлого, хууль эрх зүйн орчинд зорилтот бүлгийн эрх ашгийг төлөөлөх ИНБ-уудын тэгш оролцоог хангах, бодлого, хууль, эрх зүйн нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх үндсэн зорилготой.

ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД:

I. Цахим шилжилтийн бодлого, хууль эрх зүйн баримт бичигт ИНБ-уудын тэгш оролцоог хангахын тулд бодлогын нөлөөллийн ажил хийх.

Зорилт 1: Төрийн зүгээс цахим шилжилтийн тэгш оролцоог хангасан бодлого, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

II. ИНБ-уудын цахим үр чадварыг дээшлүүлэх.

Зорилт 2: ИНБ-ууд өөрсдийн үйл ажиллагааг болон зорилтот бүлгийн иргэдэд зориулан үзүүлж буй үйлчилгээг мэдээлэл харилцааны технологиор дамжуулан хүргэснээр цаг хугацаа хэмнэж, тэгш оролцоог хангаж, ИНБ нь өөрөө чадавхжина.

III. Зорилтот бүлгийн иргэдийн цахим үр чадварыг дээшлүүлэх, цахим шилжилтэд иргэдийн тэгш оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх цахим шилжилтэд тэгш оролцоо иргэнийг дэмжих.

Зорилт 3: Төрөөс үзүүлж буй цахим үйлчилгээ, мэдээллийг иргэдэд уншигдахуйц, харагдахуйц, сонсогдохуйц, хүртэхуйц байдлаар хөгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийн өвөрмөц хэрэгцээ, онцлогт тохирсон сургалтыг нийслэл, орон нутгийн иргэдэд тэгш хүртээмжтэй зохион байгуулснаар цахим шилжилтэд иргэдийн тэгш оролцоо хангагдах суурь тавигдана.

ДЭМЖИХ ЧИГЛЭЛҮҮД:

I. Сурталчлан таниулах.

Зорилт 4: Цахим шилжилтийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг сурталчлан таниулснаар олон нийтийн дунд ИНБ, зорилтот бүлгийн иргэдийн хэрэгжүүлж байгаа ажил, санаачилгын талаар мэдээлэл, ойлголттой болж цаашид хэрэгжүүлэх ажилд нь дэмжлэг түслалцаа үзүүлэх болон хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

II. Тайлагналт, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх.

Зорилт 5: Цахим шилжилтийг нэмэгдүүлэх нөлөөллийн замын зураглалын хүрээнд хэрэгжүүлж буй ажил, хөтөлбөр, төсөл, санаачилгын талаар тогтмол мэдээлж, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг нээлттэй тайлагнаснаар ил тод байдал, талуудын хариуцлага дээшилж, олон нийт, оролцогч талуудын ИНБ-үүдэд итгэх итгэл нэмэгдэнэ.

ЗАМЫН ЗУРАГЛАЛЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД:

- Зорилтот бүлгийн эрх ашгийг төлөөлдөг ИНБ-ууд
- Пипл Ин Нийд ОУТББ, Фаро Фаундэйшн ТББ,
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам,
- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам,
- Боловсролын яам,
- Хууль зүй, дотоод хэргийн яам
- Олон улсын байгууллагууд: Европын Холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллага (Хүүхдийн сан, Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан), Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, г.м.
- Бусад.

ЗАМЫН ЗУРАГЛАЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТ, ХИЙХ АЖЛУУД

Тэргүүлэх чиглэл 1: Цахим шилжилтийн бодлого, хууль эрх зүйн баримт бичигт ИНБ-уудын тэгш оролцоог хангахын тулд бодлогын нөлөөлөл хийх.

Зорилт 1: Төрийн зүгээс цахим шилжилтийн тэгш оролцоог хангасан бодлого, хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

Тэргүүлэх чиглэл 1-ийн хүрээнд бодлого, эрх зүйн орчинтой холбоотой дараах үйл ажиллагааг төлөвлөсөн болно.

1.1 Бодлогын чиглэлд хийх ажлууд:

- Монгол Улсын дунд хугацааны бодлогын зорилтот хөтөлбөрүүдэд цахим шилжилтийн салбар дундын зохицуулалтыг тусгах, богино хугацааны бодлогод нэгдсэн стратегийг бий болгож, цахим шилжилтийн нэр томъёо, ойлголтыг нутагшуулах;
- Монгол Улсын дунд хугацааны бодлогод “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах;
- Салбар дундын зохицуулалтын хүрээнд цахим тэгш оролцоог хангах;
 - ✓ Төрийн байгууллагын цахим хуудсанд иргэдийн оролцоог хангахад шаардлагатай харагдахуйц, уншигдахуйц байх гэх мэт тодорхой шаардлагуудыг (WCAG стандарт-ын дагуу¹³) тавих;
 - ✓ Бодлого боловсруулахад иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө гаргах, цахим оролцооны порталтай болгох;
 - ✓ Иргэдээс санал авдаг, эргэх холбоотой байх ба ирсэн санал нь бодлогод туссан талаар мэдээлж байх, онлайнаар зорилтот бүлгийн иргэдийг оролцуулсан зөвлөлдөх үйл ажиллагаа (форум, санал авах, асуулга явуулах, г.м.) зохион байгуулах.
- Харилцаа холбоо, цахим, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хууль, эрх зүй, байгаль орчин зэрэг салбарын төсөв, зарцуулалттай холбоотой мэдээллийг иргэдийн онцлогт суурилан хүргэх, иргэдээс төсөвтэй холбоотой санал авах, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах талаар иргэдтэй зөвлөлдөх, иргэдийг шийдвэр гаргах процесст хамруулах ажлыг хэрэгжүүлэх;
- Зорилтот бүлгийн иргэдийн цахим оролцоог хангахын тулд өгөгдлийг нээлттэй болгох, мэдээлэл, үйлчилгээг цахим болон уламжлалт гэсэн хосолмол аргаар хүргэх, мэдээлэл, үйлчилгээний загвар боловсруулахдаа зорилтот бүлгийн иргэдийг оролцуулах замаар хэнийг ч орхигдуулахгүй байх олон улсын зарчмыг¹⁴ тусгах.

¹³ WCAG (Web content accessibility guideline) буюу Вэбийн агуулгыг хүртээмжтэй байлгах заавар стандарт <https://www.w3.org/TR/WCAG21/>

¹⁴ <https://unsdg.un.org/2030-agenda/universal-values/leave-no-one-behind>

1.2 Хууль, эрх зүйн орчны чиглэлд хийх ажлууд:

- УИХ-аас 2021 онд баталсан цахим багц хуулиудын уялдаа холбоо болон эдгээр хуулийн хэрэгжилтээр зорилтот бүлгийн иргэдийн үндсэн эрх зөрчигдөж байгаа эсэхийг үнэлж, үр дагаврыг тодорхойлох үнэлгээ хийж шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, батлуулах;
- 2024 онд УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан (хууль тогтоомжийг сайжруулах, санал, дүгнэлт бэлтгэх, хууль болон тогтоолын төсөл бэлтгэх, өргөн мэдүүлэх үүрэг бүхий) 54 ажлын хэсэгт ИНБ-ууд тухайн зорилтот бүлгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлын хүрээнд хамаарах чиглэлээр нөлөөллийн ажил явуулах, судалгаа, шинжилгээ хийх, хамтран ажиллах;
- ИНБ-уудын эвлэлдэн нэгдэх гол хууль болох “Төрийн бүс байгууллагын тухай хууль”-ийн шинэчлэлттэй холбогдуулан Холбоо, сангийн тухай хуулийн төслийн талаар оролцогч талуудын зөвшилцлийг зохион байгуулах, нөлөөллийн ажил явуулах;
- УИХ-аас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 22.9 дэх заалтад цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх, цахим үр чадвар дээшлүүлэх үйл ажиллагааг хамруулах боломжийг судлах, холбогдох хуулийн төслийг боловсруулах.

Тэргүүлэх чиглэл 2: Иргэний нийгмийн байгууллагуудын цахим үр чадварыг дээшлүүлэх.

Зорилт 2: ИНБ-ууд өөрсдийн үйл ажиллагааг болон зорилтот бүлгийн иргэдэд зориулан үзүүлж буй үйлчилгээг мэдээлэл харилцааны технологиор дамжуулан хүргэснээр цаг хугацаа хэмнэж, тэгш оролцоог хангаж, ИНБ нь өөрөө чадавхжина.

- Тодорхой зорилтот бүлгийн эрх ашгийг төлөөлдөг ИНБ-уудыг тусгай зориулалтын тоног төхөөрөмжөөр хангаснаар зорилтот бүлгийн иргэдийг мэдээллээр хангах, үйлчилгээ үзүүлэх орчинг сайжруулах;
- Их өгөгдөл, мэдээллийн найдвартай, аюулгүй байдал, мэдээллийн нууцлал, хиймэл оюун ухаан зэрэг сэдвийн сургалтыг хот, хөдөөгийн ИНБ-уудад давтамжтайгаар зохион байгуулах;
- Зорилтот бүлгийн иргэдийн оролцоог дэмжих зорилгоор аливаа төрийн мэдээлэл, үйлчилгээг нэвтрүүлэхийн өмнө тэдний эрх ашгийг төлөөлсөн ИНБ-уудтай хамтран загвар боловсруулж, турших;

Хэрэв дээрх дэд зорилтууд биелэгдвэл, ИНБ-уудын дотоод үйл ажиллагааг цахимжуулахад чиглэсэн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх нь чухал.

Тэргүүлэх чиглэл 3: Зорилтот бүлгийн иргэдийн цахим үр чадварыг дээшлүүлэх, иргэд цахим шилжилтэд тэгш оролцоход дэмжлэг үзүүлэх.

Зорилт 3: Төрөөс үзүүлж буй цахим үйлчилгээ, мэдээллийг иргэдэд уншигдахуйц, харагдахуйц, сонсогдохуйц, хүртэхуйц байдлаар хөгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийн өвөрмөц хэрэгцээ, онцлогт тохирсон сургалтыг нийслэл, орон нутгийн иргэдэд тэгш хүртээмжтэй зохион байгуулснаар цахим шилжилтэд иргэдийн тэгш оролцоо хангагдах суурь тавигдана.

- Төрийн байгууллагуудад зорилтот бүлгийн иргэдийн оролцоог хангахын тулд нөхцөлийг нь бүрдүүлэх стандартыг бий болгох ба үүнд ИНБ-ууд идэвхтэй оролцох (тэгш оролцоотой болгох – уулзалтын өрөөтэй байх, мэдээллийн самбар бий болгох, мэдээлэл байршуулах);
- ИНБ нь шинээр хэрэгжүүлэх гэж байгаа цахим үйлчилгээний талаар зорилтот бүлгийн иргэдээс санал авч, ирсэн саналыг загварчилж хөгжүүлэхэд тусгах талаар нөлөөллийн ажлыг зохион байгуулж, цахим үйлчилгээг турших, нэвтрүүлэхэд иргэдийг идэвхтэй оролцуулж, ашиглахад нь дэмжлэг тусалцаа үзүүлэх;
- ИНБ нь зорилтот бүлгийн иргэдийн цахим мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, интернэтийн холболтыг дээшлүүлэх, тусгай хэрэгслээр хангах зэрэг ажлыг зохион байгуулах;
- ИНБ-ууд нь зорилтот бүлгийн иргэдийн цахим оролцооны хэмжүүр боловсруулах ажлыг санаачлан, холбогдох салбарын яам, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, цахим оролцооны хэмжүүрийн ач холбогдлын талаар нөлөөллийн ажлыг зохион байгуулж, батлуулсны дараа олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах;
- ИНБ нь цахим бичиг үсэг тайлалт, үр чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтыг зохион байгуулах, онлайн сургалтын хэрэгсэл эсвэл цахим хуудас хөгжүүлэх, сургалтын гар утасны аппликейшн хөгжүүлэх зэрэг ажлыг гардан зохион байгуулах.

ЗАМЫН ЗУРАГЛАЛЫН ДЭМЖИХ ЧИГЛЭЛҮҮД:

Дэмжих чиглэл 1: Сурталчлан таниулах

Зорилт 4: Цахим шилжилтийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг сурталчлан таниулснаар олон нийтийн дунд ИНБ, зорилтот бүлгийн иргэдийн хэрэгжүүлж байгаа ажил, санаачилгын талаар мэдээлэл, ойлголттой болж цаашид хэрэгжүүлэх ажилд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх болон хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

- Олон нийт болон зорилтот бүлгүүдэд хүртээмжтэй хэл, медиа форматыг ашиглан мэдээлэл хүргэх онлайн кампанит ажлыг зохион байгуулж, хүртээмжтэй цахим шилжилтийн ач холбогдол, оролцох боломжуудыг онцлон сурталчлах;
- Янз бүрийн хүн амд хүрч, харилцааны хүртээмжийг сайжруулахын тулд хадмал орчуулга, дохионы хэл, аудио тайлбар зэрэг хүртээмжтэй форматаар видео, инфографик, сошиал медиа пост гэх мэт медиа контент боловсруулж, түгээх.

Дэмжих чиглэл 2: Хяналт-шилжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах,

Зорилт 5: Цахим шилжилтийг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалын хүрээнд хэрэгжүүлж буй ажил, хөтөлбөр, төсөл, санаачилгын талаар тогтмол мэдээлж, хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг нээлттэй тайлагнаснаар ил тод байдал, талуудын хариуцлага дээшилж, олон нийт, оролцогч талуудын ИНБ-уудад итгэх итгэл нэмэгдэнэ.

- Замын зураглалын хүрээнд хөтөлбөр, төсөл, ахиц дэвшлийн талаар улирлын тайлан, шинэчлэл мэдээллийг тодорхой, ойлгомжтой форматаар (жишээ нь, онлайн хяналтын самбар, мэдээллийн хуудас) нийтэлж, олон нийтийг мэдээллээр хангах;
- Хот, хөдөөгийн бүсэд уулзалт, санал солилцох арга хэмжээг зохион байгуулж, иргэдэд иргэний нийгмийн байгууллагуудтай шууд харилцах, асуулт асуух, цахим шилжилтийн үйл ажиллагааны талаар санал бодлоо хуваалцах боломжийг олгох;
- Онлайн портал байгуулж, нарийвчилсан хяналтын үр дүн, төслийн хэрэгжилтийн тайланг ил тод нийтэлж, олон нийтийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх, гол санаачилга, гарсан үр дүн зэргийг цаг тухайд нь харуулан нээлттэй байдлыг хангах.

Замын зураглалыг хэрэгжүүлснээр гарах үр дүн:

1. Монгол Улсын ИНБ-ууд нь цахим шилжилтийн бодлого, хууль эрх зүйн талаар мэдээлэл, мэдлэгтэй болсноор бодлого, хууль эрх зүйн баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх явцад идэвхтэй оролцож, дэвшүүлсэн зорилгод хүрч байгаа эсэхэд олон нийт хяналт тавих мэдлэгтэй болох үндэс тавигдана.
2. Монгол Улсын ИНБ-уудын цахим үр чадвар дээшилж, цахим технологийн хэрэгслийг ашиглан зорилтот бүлгийн өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн мэдээлэл хүргэх, мэдлэг, ойлголтыг нь дээшлүүлэхэд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг чадварлаг байгууллага болно.
3. Зорилтот бүлгийн иргэд нь мэдээлэл, үйлчилгээг биеэр болон цахимаар чирэгдэл, бэрхшээлгүй шууд авснаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх нөхцөл нь бүрдэж, ингэснээр цахим шилжилтэнд зорилтот бүлгийн иргэдийн тэгш оролцоо хангагдаж, нийгмийн идэвхтэй иргэд болох үндэс суурь тавигдана.

Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалын үйл ажиллагааны төлөвлөгөө

Хүснэгт 4. Цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын замын зураглалын үйл ажиллагааны төлөвлөгөө

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үйл ажиллагааны тодорхойлолт / Хүлээгдэж буй үр дүн	Шалгуур үзүүлэлт	Оролцогч талууд ¹⁵
1	ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ИНБ-УУДЫН ТЭГШ ОРОЛЦООГ ХАНГАХ, БОДЛОГЫН НӨЛӨӨЛЛИЙН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ			
Бодлогын чиглэлд хийх ажлууд:				
1.1	Монгол Улсын дунд хугацааны бодлогод “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах зорилтот хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах, нөлөөллийн ажил хийх;	• “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын хөтөлбөр” батлагдсан байх. • Нөлөөллийн ажлын хүрээнд зорилтот оролцогч талуудын өгсөн санал, зөвлөмжийг тусгасан байдал.	• “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын хөтөлбөр” батлах талаар Нөлөөллийн ажилд оролцсон төрийн байгууллагууд, ИНБ-уудын тоо. • Нөлөөллийн ажилд оролцогчдын дэвшүүлсэн, өргөн барьсан санал, зөвлөмжийн тоо.	ИНБ-ын төлөөллүүд, Засгийн газар, УИХ -ын даргын тушаалаар баталсан ажлын хэсэг
1.2	ИНБ-ын бүлэг байгуулах, сургалтанд хамруулах	• ИНБ-ын бүлэг байгуулагдаж зорилтот иргэдийн эрх ашгийг хамгаалах, тусгах зэрэг асуудалд тууштай хандах боломж бүрдсэн байх. • Цахим эрх, бодлогын нөлөөллийн кампанит ажил зохион байгуулах, хууль эрх зүйн талаар сургалтанд хамрагдсанаар ИНБ-ын бүлгийн гишүүдийн цахим эрх, бодлогын нөлөөллийн кампанит ажил зохион байгуулах үр чадвар, хууль эрх зүйн талаар мэдлэг дээшилсэн байх.	• Сургалтад хамрагдсан ИНБ-ын тоо • Зохион байгуулсан нөлөөллийн кампанит ажлын тоо	ИНБ, ЦХИХХЯ, И-Монгол академи
1.3	Салбаруудын дунд хугацааны 10 жилийн зорилтот хөтөлбөрт “Цахим шилжилт”-тэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилт, шалгуур үзүүлэлтийг хэрхэн тусгаж, тодорхойлох талаар хэлэлцүүлэг хийх	• ИНБ-ууд, салбарын яамдуудын төлөөллийг оролцуулсан “Цахим шилжилттэй холбоотой хэлэлцүүлэг зохион байгуулсан байх. • Хэлэлцүүлгээс санал, зөвлөмж гаргасан байна. Хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсэгт 2-3 ИНБ-уудын төлөөлөл орсон байх.	• Хэлэлцүүлэгт оролцсон ИНБ, төрийн байгууллагын тоо • Бодлого боловсруулагчдад хүргүүлсэн санал, зөвлөмжийн тоо • Хэлэлцүүлэгт оролцогчдын бэлтгэсэн санал, зөвлөмжийг тусгасан бодлого, шийдвэрийн тоо	ИНБ-ын төлөөллүүд, Салбарын яамдууд ЦХХХЯ-ны “Цахим үндэстэн” баримтлах чиглэл.

¹⁵ Энэ баганад байгаа оролцогч талууд нь цахим шилжилт болон тэгш оролцоог хангах талаар тодорхой ажлууд төлөвлөөд хийж байгаа (төсөв, хугацаа, нөөц бололцоог тодорхойлсон) бөгөөд тэдгээрийн хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чиг хүрээ, төсөл хөтөлбөрийн мэдээллийг тайлангийн НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ хэсгээс харна уу. Түүнчлэн замын зураглал боловсруулах ажлын эцсийн тайлангаас Монголын оролцогч талуудын дэлгэрэнгүй шинжилгээтэй танилцах боломжтой.

1.4	Салбар дундын зохицуулалтын хүрээнд цахим шилжилтийн тэгш оролцоог хангах нөлөөллийн ажлыг зохион байгуулах;	• Төрийн байгууллагын вэб хуудас иргэдийн оролцоог хангахад шаардлагатай тодорхой (харагдахуйц, уншигдахуйц, сонсогдохуйц гэх WCAG 2.1 стандартын дагуу) шаардлагуудыг биелүүлсэн байх. • Бодлого боловсруулахад иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө гаргасан байх. • Цахим оролцооны порталтай болсон байх. (Иргэдээс санал авдаг, эргэх холбоотой байх ба ирсэн санал нь бодлогод туссан талаар мэдээлж байх, зорилтот бүлгийн иргэдийг оролцуулсан онлайн зөвлөлдөх үйл ажиллагааг (форум, санал авах, асуулга явуулах, г.м.) зохион байгуулах)	• Иргэдээс санал авсан тоо, эргэж мэдээлэл хүргүүлсэн байдлыг илэрхийлсэн мэдэгдэл, явуулсан мэйлийн тоо • Тусгай шаардлагуудыг хангасан төрийн цахим хуудасны тоо • Зорилтот бүлгийн иргэдийг оролцуулсан үйл ажиллагааны тоо, оролцсон болон хамрагдсан иргэдийн тоо • Цахим оролцооны портал ашиглан зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтын тоо • Цахим портал дээрх зөвлөлдөх уулзалтын үр дүнд үндэслэн батлагдсан арга хэмжээ, шийдвэр, бодлогын тоо	ИНБ, ЦХХХИЯ, ЗГХЭГ-ын 1111 төв, УИХ-ын d-parliament, Олон улсын байгууллага (ОУБ)
1.5	ИНБ-ын и-мэйлийн групп үүсгэж, түүгээр мэдээ, мэдээлэл, зар зэргийг хүргэх	• 20 гаруй ИНБ-уудын мэйлийн лист үүсгэсэн байх. • Мэйлийн листээр 4-оос доошгүй мэдээ, мэдээлэл, зар зэргийг түгээсэн байх.	• Түгээсэн мэдээллийн тоо • Түгээсэн мэдээлэл дээр үндэслэн зохион байгуулсан хэлэлцүүлэг, зөвлөгөөний тоо	ИНБ
1.6	ИНБ-уудын портал сайт үүсгэх. Портал сайт хөгжүүлэх компанийг сонгон шалгаруулах	• ИНБ-ыг бүртгэж, мэдээлэл оруулах болон мэдээ, мэдээлэл авах, хуваалцах, хамтран ажиллах талбар болох портал сайт үүсгэсэн байх.	• Портал сайтад бүртгэгдсэн ИНБ-ын тоо • Портал сайтын хандалтын тоо • Портал сайт дээр байршуулсан мэдээ, мэдээллийн тоо • Портал сайтыг хүртээмжтэй, хэрэгцээтэй, хэрэглэгчдэд ээлтэй гэж үнэлсэн хэрэглэгчдийн хувь	ИНБ
1.7	ИНБ-ын портал сайтын талаар сургалт зохион байгуулах	• 40-50 ИНБ-ыг хамруулсан сургалтыг зохион байгуулсан байх. Ингэхдээ сургалтыг бүлэглэсэн хэлбэрээр зохион байгуулбал илүү үр дүнтэй болно.	• Сургалтанд хамрагдсан ИНБ-ын тоо, сургалтын үр дүнд портал сайтад бүртгүүлсэн ИНБ-ын тоо	ОУБ
1.8	Портал сайтын үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжлэг туслалцаа үзүүлэх байгууллагатай гэрээ байгуулах	• ИНБ болон иргэдийг оролцуулсан онлайн зөвлөлдөх уулзалтыг портал сайтаар тогтмол, тасралтгүй зохион байгуулах боломжтой болсон байх.	• Портал сайтад бүртгэлтэй ИНБ-ын тоо • Дэмжлэг туслалцаа үзүүлсэн ИНБ-ын тоо, бүртгэл • ИНБ-аас портал сайтын үйл ажиллагаатай холбоотой ирсэн саналын тоо, шийдвэрлэсэн байдал, ИНБ-д тулгарч буй асуудлыг нэгтгэсэн тайлан	ОУБ, хувийн хэвшил
1.9	ЦХИХХЯ, ГБХНХЯ-тай хамтран ИНБ-д мэдээлэл өгөх, санал бодол солилцох семинар зохион байгуулах	• Семинарын үеэр дэвшүүлсэн саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээ, мэдээллийг портал сайт болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байх.	• ИНБ болон ЦХИХХЯ, ГБХНХЯ-ны төлөөлөл зэрэг семинарт оролцогчдын тоо	ИНБ, УИХ, Д-парламент

1.10	Д-парламент, и-парламент, 1111.мн, г.м. бодлогын баримт боловсруулах иргэдийн оролцоог хангах вэб, апп зэргийг ашиглаж, саналаа оруулах талаар сургалт зохион байгуулах	- ИНБ-ыг олон төрлийн технологи, платформ ашиглан оролцоонд суурилсан зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, бодлогын санал боловсруулах чадамжийг нэмэгдүүлэх. - Дэмжигдээгүй саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээ, мэдээллийг портал сайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн байдал.	- Олон төрлийн платформуос цуглуулсан нотолгоонд үндэслэн бодлогын баримт бичиг боловсруулах чадвартай болсон ИНБ-ын тоо - Д-парламентэд ИНБ тэгш оролцоог хангахтай холбоотой оруулсан саналын тоо. - Шийдвэрт тусгагдсан саналын тоо.	ИНБ, УИХ, Д-парламент
1.11	ЦХИХХЯ, ГБХНХЯ, БЯ-наас тэргүүлэн тэдгээрийн вэб хуудас, олон нийтийн сүлжээнд хүргэж буй мэдээллийг зорилтот бүлгийн иргэдэд зориулж контентыг бүтээх ажлыг үргэлжлүүлэн тууштай зохион байгуулах	Энэ ажлыг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө, хариуцах мэргэжилтэн, технологийн шийдэл зэрэг агуулсан хөтөлбөр боловсруулсан байх. Шаардагдах төсөв, хөрөнгө, санхүүжилтийг шийдсэн байх.	- Зорилтот бүлгийн иргэдэд зориулж бүтээсэн контентын тоо, - Үзэлт / хандалтын тоо, ирүүлсэн санал.	ЦХИХХЯ, ГБХНХЯ, БЯ, ИНБ
1.12	Бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	- Сургалтын хөтөлбөрийг хот, хөдөөгийн ИНБ-д оролцуулахаар боловсруулсан байх. - Хотын 5 ИНБ, хөдөө орон нутгийн 5 ИНБ байгууллага оролцсон байх.	Бодлогын баримт бичгийн шинжилгээнд суурилсан сургалт, сайн туршлагын (кейс судалгаа) баримтжуулалтад оролцсон ИНБ-ын тоо	ОУБ
1.13	Төрийн байгууллагуудын вэб сайт, апп, тэдгээрийг ашиглах зааварчилгаа бүхий материал боловсруулах	Дараах аппликэйшнүүдийн хүрээнд 5 төрлийн гарын авлага боловсруулсан байх. (төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн систем, худалдан авах ажиллагааны портал, 11-11 иргэдэд үйлчилдэг төв, орон нутгийн хөгжлийн сан, https://www.esis.edu.mn/hr/index.html#/)	- Гарын авлагыг татаж авсан хэрэглэгчийн тоо - Гарын авлагыг хэрэгцээтэй гэж үнэлсэн ашиглагчийн хувь	ЦХИХХЯ, ХХЗХ, НҮБ
1.14	Хөдөө орон нутгийн зорилтот бүлгийн ИНБ болон иргэдэд цахим шилжилтийн тухай хууль эрхзүйн талаар сургалт зохион байгуулах	- Сургалтын хөтөлбөр нь сургалтын төлөвлөгөө (бүсчилсэн, аймаг бүр дээр, г.м.), хамрах хүрээ, сургалтын агуулга, сургагч багш нар бэлтгэх аргачлал зэргийг оруулсан байх. - Цахим шилжилтийн талаар сургалт хамрагдсанаар ойлголт мэдлэг дээшлэх.	Сургалтанд хамрагдсан ИНБ болон иргэдийн тоо	ЦХИХХЯ

Хууль, эрх зүйн орчны чиглэлд хийгдэх ажлууд:				
1.15	ИНБ-ын талаар Төрөөс баримтлах бодлого, хууль зүйн орчныг сайжруулах талаар хэлэлцүүлэг зохион байгуулах	- Төр, хувийн хэвшил, ИНБ-уудын төлөөллийг хамруулан цаашид баримтлах бодлого, хууль эрх зүйн орчны талаар санал, зөвлөмж гаргасан хэлэлцүүлэг зохион байгуулах. (Шаардлагатай тохиолдолд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан 2024 онд УИХ-ын даргын захирамжаар байгуулсан 54 Ажлын хэсгүүдтэй хамтран ажиллах) - Хэлэлцүүлгээр дэвшүүлсэн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар олон нийтэд мэдээллэсэн байх (портал сайт дээр байршуулсан мэдээ, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээсэн байх) - ИНБ-ын дунд төрөөс баримтлах бодлого хууль, эрх зүйн орчны талаар мэдээлэл, ойлголттой болно.	- Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо - Хэлэлцүүлэгт хамрагдсан ИНБ, иргэд, төр болон хувийн хэвшлийн төлөөллийн тоо	УИХ-ын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгүүд, ЦХИХХЯ, ХЗДХЯ, ЭЗХЯ, ОУБ
1.16	УИХ-аас 2021 онд баталсан цахим багцалсан хуулиудын уялдаа холбоо, түүнд зорилтот бүлгийн иргэдийн үндсэн эрх зөрчигдөж буй эсэх асуудлаар түүний хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, холбогдох нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулах, батлуулах;	- ИНБ-уудын төлөөллийг хамруулан цаашид баримтлах бодлого, хууль эрх зүйн орчны талаар санал, зөвлөмж гаргасан байх. - Цахим багцаалсан хуулийн талаар ИНБ-ын мэдээлэл, мэдлэг, ойлголт дээшилсэн байх.	- Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулсан саналын тоо - Өргөн барьсан саналыг тусгасан хууль, хуулийн нэмэлт заалтын тоо	УИХ, ЦХИХХЯ, ХЗДХЯ
1.17	ИНБ-ын эвлэлдэн нэгдэх гол хууль болох “Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн шинэчлэлтэй холбогдуулан Холбоо, сангийн тухай хуулийн төслийн талаар оролцогч талуудын зөвшилцлийг зохион байгуулах, нөлөөллийн ажил явуулах;	ИНБ-уудын төлөөллийг хамруулан цаашид баримтлах бодлого, хууль эрх зүйн орчны талаарх санал, зөвлөмж болон хамтран ажиллах төлөвлөгөө гаргасан байх.	- Зохион байгуулсан арга хэмжээнд (уулзалт, хэлэлцүүлэг, ярицлага) зэрэгт хамрагдсан ИНБ-ын тоо - Арга хэмжээний үр дүнд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо	УИХ-ын даргын захирамжаар байгуулсан Ажлын хэсэг, Засгийн газар

1.18	УИХ-аас 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийн 22.9-дэх заалтад цахим шилжилтийн тэгш оролцоог нэмэгдүүлэх, цахим ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг хамруулах боломжийг судлах, холбогдох хуулийн төслийг боловсруулах;	ИНБ-уудын төлөөллийг хамруулсан ажлын хэсэг байгуулан судалгаа хийж, хуулийн төсөл боловсруулсан байх.	Хамрагдсан ИНБ-ын тоо, хуулийн төслийг өргөн барьсан талаарх мэдээ мэдээллийг портал сайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн байдал	УИХ-ын даргын захирамжаар байгуулсан Ажлын хэсэг, Засгийн газар
1.19	ИНБ-дад цахим хууль, зохицуулалт, цахим засаглалын тэргүүн туршлага зэргийг агуулсан номын сан бий болгох (онлайн хэлбэрээр бас хөгжүүлэх)	- Цахим засаглал, цахим хууль, зохицуулалттай холбоотой ном, гарын авлага, баримт бичиг, удирдамж зэргийг агуулсан номын санг бий болгосон байх. - Онлайн эх үүсвэрийг агуулсан өгөгдлийн сан бий болгосон байх.	- Номын санг ашигласан ИНБ, иргэдийн тоо, эрэлт хэрэгцээтэй ном, гарын авлага, баримт бичгийн бүртгэл - Өгөгдлийн санд байгаа ном, гарын авлага, бодлогын зөвлөмж зэргийн тоо - Өгөгдлийн санд хандсан хандалтын тоо - Өгөгдлийн сантай холбоотой ирсэн санал, шүүмжлэл, зөвлөмжийн бүртгэл.	ОУБ
1.20	Цахим шилжилттэй холбоотой хууль эрхзүйн баримт бичиг боловсруулах ажлын хэсэгт ИНБ-ын төлөөллийг оролцуулах	2-3 зорилтот бүлгийн төлөөллийн ИНБ-уудыг ажлын хэсэгт оролцуулсан байх.	Ажлын хэсгийн боловсруулсан хууль эрх зүйн баримт бичгийн тоо	ЦХИХХЯ, ДГХБО ОУСТ, ХЗДХЯ
1.21	И-парламент, и-partisипейшн, 11-11 зэрэг хэрэгслээр дамжуулан санал, өргөдөл боловсруулах, санал өгөх талаар сургалт зохион байгуулах	Сургалтын төлөвлөгөө, гарын авлага зэргийг боловсруулсан байх. Ингэхдээ гарын авлагыг зорилтот бүлгийн иргэдэд зориулан боловсруулах.	Сургалтанд хамрагдсан ИНБ, иргэдийн тоо	УИХ-ын и-парламент, и-partisипейшн, ЗГХЭГ-ын 11-11,
1.22	Олон нийтийн зөвлөлдөх ажлыг (public consultation) зохион байгуулах талаар гарын авлага боловсруулж, кейсүүд хийх	Гарын авлага нь зорилтот бүлгийн иргэдэд зориулан боловсруулсан байх ба 2 кейсийн видео хийсэн байх.	- Боловсруулсан гарын авлага, видео ашигласан ИНБ-ын тоо - Гарын авлага болон видео хэрэгцээтэй гэж үнэлсэн ИНБ-ын хувь	ЦХИХХЯ

2	ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ			
2.1	ИНБ-ыг цахим шилжилттэй холбоотой хууль эрх зүй, бодлогын баримт боловсруулах явцад идэвхтэй оролцоход шаардлагатай ИНБ-ын дотоод үйл ажиллагааг цахимжуулах ажлын төлөвлөгөө боловсруулах	Ажлын төлөвлөгөө боловсруулсан байх.	- Дотоод үйл ажиллагааг цахимжуулсан ИНБ-ын тоо, ашигласан хэрэгсэл, - Хэрэглэгчийн тоо	ЕХ, ШХА, НҮБ, Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо
2.2	ИНБ-уудын дотоод үйл ажиллагааг цахимжуулах талаар сургалтын хөтөлбөр боловсруулах	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна. Түс хөтөлбөр нь дараах хэсгээс бүрдсэн байна. Үүнд: 1)ИНБ-ыг дотоод үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны хэрэгсэл ашиглах үр чадварыг дээшлүүлж, эзэмшүүлэх (файл сервер, дотоод сүлжээ, файл хуваалцах, солилцох, мэйлийн систем нэвтрүүлэх, Майкрософтын Ворд, Эксел, Поуэр Пойнт зэргийг ашиглаж сурах, 2)Төлөөлж буй иргэд болон бусад ИНБ болон бусад байгууллагатай харилцах үр чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн (мэйл ашиглах аргачлал, мэйлийн лист ашиглах дадлага, вэб хуудсын мэдээллийг шинэчлэх, өөрчлөх, портал сайт дээр хэлэлцүүлэг өрнүүлэх, онлайнаар асуулга хийх, үр дүнг боловсруулах хэрэгсэл, г.м.) 3)Цахим шилжилттэй холбоотой үг хэллэг, ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн (тайлбар толь, цахим шилжилттэй холбоотой бусад орны тэргүүн түршлага, тайлагнах, сэтгүүлд нийтлэл бичих, вэбээс мэдээлэл хайх, боловсруулах, г.м.)	Шаардлагатай агуулгыг багтаасан сургалтын хөтөлбөр	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ
2.3	Сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулах	ИНБ-ууд дотоод үйл ажиллагаагаа цахимжуулах боломжтой болох.	- Сургалтанд хамрагдсан зорилтот бүлгийн төлөөлөл ИНБ тоо - Сургалтыг хэрэгцээтэй гэж үнэлсэн ИНБ-ын хувь - Сургалтын талаар ирүүлсэн санал, зөвлөмж	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ
2.4	Сургалт бүрийн дараа үнэлгээ хийгдэж ИНБ-аас ирсэн саналын дагуу сургалтын хөтөлбөрт өөрчлөлт, засвар оруулж шинэчлэх	- Сургалтанд хамрагдсан 40 ИНБ-аас ирсэн асуулгын үр дүнг боловсруулж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулсан байна. - Сургалтад хамрагдсан ИНБ-ын мэдлэг, ойлголт дээшилсэн байна.	- Мэдлэг, ойлголт нь дээшилсэн оролцогчдын хувь. - Сургалтыг хэрэгцээтэй болон практикт хэрэгжүүлэх боломжтой гэж үнэлсэн оролцогчдын хувь	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ

2.5	Зорилтот бүлгийг төлөөлсөн ИНБ-ыг цахимжуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	• 30 зорилтот бүлгийн ИНБ-ыг тусгайлсан тоног төхөөрөмж (брэйл төхөөрөмж, дуу авиа таних програм хангамж) суурилуулах, ашиглах талаар сургалт зохион байгуулах (Call for proposals – ИНБ-аас өөрсдөөр нь санал ирүүлэх хэлбэрээр зохион байгуулж болно)	• Тоног төхөөрөмж хүлээж авсан ИНБ-ын тоо, бүртгэл, ашиглалтын бүртгэл • Сургалтад хамрагдсан иргэдийн тоо • Мэдлэг болон ур чадвараа дээшлүүлсэн иргэдийн хувь • Цахим зөвлөгөөн болон шийдвэр гаргалтын явцад оролцсон сургалтад хамрагдсан иргэдийн тоо	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ
2.6	ИНБ, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн цахим бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох кампанит ажил зохион байгуулах	• Зорилтот бүлгүүд болон тэдэнтэй хамтран ажилладаг ИНБ-ууд бэлэн байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдтэй танилцаж, эдгээр хэрэгсэлүүдийг цахим зөвлөлдөх уулзалтуудад оролцох, шийдвэр гаргах үйл явцад оролцох зорилгоор ашиглах боломжтой болох.	• Зорилтот бүлгийн иргэдэд чиглэгдсэн цахим бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо, ашигласан иргэдийн бүртгэл • Дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээг ашиглан цахим зөвлөлдөх уулзалтуудад идэвхтэй оролцсон иргэдийн хувь	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ, Монголын програм хангамж үйлдвэрлэгч-дийн холбоо
2.7	Цахим шилжилтийн тэгш оролцоог хангах санал, санаачилгыг (гарааны бизнес) дэмжих	• Бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байх.	• Санал санаачилгад хамрагдсан ИНБ, иргэдийн тоо • Хөгжүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо • Бүтээгдэхүүн, үйлчилгээг ашигласан ИНБ, иргэдийн тоо • Бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэгцээнд нийцсэн, тохиромжтой гэж үнэлсэн ИНБ, иргэдийн хувь	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ
2.8	ИНБ-уудын маркетинг болон нөлөөллийн ажил зохион байгуулах ур чадварыг хөгжүүлэх сургалт зохион байгуулах	• Маркетинг, нөлөөллийн ажлын сургалтын хөтөлбөр боловсруулж, зорилтот бүлгийн 10 ИНБ-д сургалт зохион байгуулсан байх.	• Маркетинг болон нөлөөллийн ажлын талаар гүнзгий ойлголттой болсон оролцогчдын тоо • Сургалтаас олсон мэдлэгийг практик дээр ашиглаж байгаа оролцогчдын тоо • Сургалтанд оролцсон ИНБ болон зорилтот бүлгүүдийн тоо • Кибер аюулгүй байдлын талаар мэдлэг, ур чадвараа сайжруулсан ИНБ болон зорилтот бүлгүүдийн тоо	ЕХ, Швейцарын хөгжлийн агентлаг, НҮБ
2.9	ИНБ-уудад цахим аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулж, зорилтот бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	• Цахим аюулгүй байдлын талаар 2 видео (хэрхэн таних болон сэргийлэх арга хэмжээ авах ба хувийн мэдээлэл хамгаалах талаар) хийх. • Цахим аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр боловсруулж, хот суурин газар болон хөдөө орон нутгийн 20 ИНБ-ыг хамруулах. 30 зорилтот бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулах.	• Сургалтад хамрагдсан ИНБ болон зорилтот бүлгүүдийн тоо • Кибер аюулгүй байдлын талаар мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн ИНБ болон зорилтот бүлгүүдийн тоо	ЦХИХХЯ, Монголын програм хангамж үйлдвэрлэгч-дийн холбооны гишүүн компаниуд
2.10	ИНБ-д цахим орчинд хувийн мэдээлэл хамгаалах, сэргийлэх талаар сургалт зохион байгуулах	• Хувийн мэдээлэл хамгаалах, сэргийлэх талын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сургалтын агуулга, үзүүлэн бэлдэх.	• Хамрагдсан ИНБ, иргэдийн тоо • Хувийн мэдээлэл хамгаалах талаар мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн ИНБ болон иргэдийн хувь	ЦХИХХЯ, Монголын програм хангамж үйлдвэрлэгч-дийн холбооны гишүүн компаниуд

2.11	ИНБ-д биг дата, дүн шинжилгээний талаар сургалт зохион байгуулах	Их өгөгдөл, түүнийг ашиглаж дүн шинжилгээ хийх талаар сургалтын төлөвлөгөө боловсруулж, сургалтын агуулга, үзүүлэн зэргийг бэлтгэн боловсруулах.	- Их өгөгдөл болон өгөгдөл шинжилгээний талаар боловсруулсан сургалтын төлөвлөгөө, сургалтын агуулга болон материалууд - Сургалтад хамрагдсан ИНБ, иргэдийн тоо - Их өгөгдөл, дүн шинжилгээний талаар ойлголт, мэдлэг, үр чадвар нь дээшилсэн ИНБ, иргэдийн хувь.	Хувийн хэвшил, Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо
2.12	Хиймэл оюун ухааны талаар ИНБ-д зориулсан сургалт зохион байгуулах	- ИНБ-ууд хиймэл оюун ухааныг үр ашигтай, ёс зүйтэй ашиглаж, өөрсдийн бүтээмжийг сайжруулах боломжтой болох. - Хиймэл оюун ухааны талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, сургалтын агуулга, үзүүлэн бэлтгэж, сургалт зохион байгуулах байгууллага (хувь хүнийг) сонгон шалгаруулах.	- Сургалтад хамрагдсан ИНБ, иргэдийн тоо - Хиймэл оюун ухааны талаар ойлголт, мэдлэг, үр чадвар нь дээшилсэн ИНБ, иргэдийн хувь.	Хувийн хэвшил, Монголын програм хангамж үйлдвэрлэгчдийн холбоо
2.13	Зорилтот бүлгийн иргэдэд зориулсан бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх, албан тоот боловсруулах, өргөдөл гаргах, бодлогын баримт бичгийн төсөлд санал өгөх талаар сургалт зохион байгуулах. Албан тоот боловсруулах, хариу өгөх, г.м.	- Бодлогын баримт бичигт (жишээ нь цахим шилжилттэй холбоотой, УИХ-ын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн боловсруулж байгаа бодлогын баримт бичиг) дүн шинжилгээ хийж сургалтын агуулга боловсруулах 10 ИНБ-д сургалт зохион байгуулах.	- Сургалтанд оролцсон зорилтот бүлгийн иргэдийн тоо - Сургалтын агуулгыг гүнзгий ойлгосон зорилтот бүлгийн иргэдийн хувь	ОУБ
2.14	ИНБ-д хэвлэл мэдээлэлтэй ажиллах талаар заавар зөвлөгөө, гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулах	Нийслэлийн 10, хөдөө орон нутгийн 20 ИНБ-ыг сургалтад хамруулах.	- Сургалтанд хамрагдсан ИНБ-ын тоо - Хэвлэл мэдээлэлтэй ажилласан 1-2 кейс	ОУБ
2.15	ИНБ-уудад ЕХ, Дэлхийн банк, НҮБ, АНУ-ын ЭСЯ-ны санхүүжилтийн хөтөлбөрийн талаар танилцуулах	- ЕХ (e-calls PADOR, Switch Asia program, European instrument for democracy and human rights (EIDHR) г.м хөтөлбөрүүд), USAID, Asian Foundation, НҮБ-ын Дижитал акселетор зэрэг хөтөлбөрийг танилцуулах, хөтөлбөрт хамрагдахад бүртгүүлэх тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах. - Нийслэлийн 10, хөдөө орон нутгийн 30 ИНБ-д сургалт зохион байгуулах.	- Олон төрлийн санхүүжилтийн боломжуудын талаар гүнзгий ойлголттой болсон ИНБ-ын тоо - Санхүүжилтийн боломжуудын талаар олгосон мэдээллийг хэрэгцээтэй гэж үнэлсэн ИНБ-ын хувь - ИНБ-уудаас танилцуулсан санхүүжилтийн боломжуудад хүргүүлсэн саналын тоо - Санхүүжилт авсан ИНБ-ын тоо	ОУБ, АНУ-ын олон улсын хөгжлийн агентлаг, Азийн сан, НҮБ-ын дижитал акселератор хөтөлбөр, ЕХ-ны “Switch Asia program”

2.16	Тэтгэлэг авах санал боловсруулах, тэтгэлгийн төсөл боловсруулах, төслийн менежментийн талаар сургалт зохион байгуулах (жишээ нь Европын холбооны e-calls PADOR дээр зарлаж буй тэтгэлэгт хамрагдах)	• Нийслэлийн 10, хөдөө орон нутгийн зорилтот бүлгийн 30 ИНБ-ыг сургалтад хамруулах.	• Ур чадвараа сайжруулсан ИНБ-ын тоо • Сургалтыг хэрэгцээтэй гэж үнэлсэн ИНБ-ын хувь	EX-ын e-calls PADOR
2.17	Санхүүжилтийн хөтөлбөрийн дагуу санал боловсруулж батлуулж, хөтөлбөр хэрэгжүүлэх	• 5-7 ИНБ төсөл хэрэгжүүлж, үр дүнг танилцуулах	• Танилцуулсан санхүүжилтийн боломжуудад ИНБ-уудаас хүргүүлсэн саналын тоо • Санхүүжилт авсан ИНБ-ын тоо • Боловсруулсан төсөл санаачилгын тоо	EX-ын e-calls PADOR
3	ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, ЦАХИМ ШИЛЖИЛТЭНД ТЭГШ ОРОЛЦОХ ИРГЭНИЙГ ДЭМЖИХ			
3.1	Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах	Тодорхой зорилтот бүлэг (хараагүйчүүд, сонсголын бэрхшээлтэй, ахмад настан, хүүхэд залуучууд, малчид, г.м.)-т чиглэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулах. Сургалтын хөтөлбөр нь дараах агуулгатай байна. Үүнд: 1. Онлайн байгаа бүх мэдээллийг тусгай төхөөрөмж ашиглаж уншиж, сонсож сурах, 2. Тусгай төхөөрөмж ашиглан онлайн контент боловсруулж сурах, 3. Сургагч багш бэлдэж, зорилтот бүлгийн бусад иргэдэд сургалт зохион байгуулах чадвартай болох. Ингэхдээ DICE төслийн хүрээнд зохион байгуулсан ажлын туршлага, сургамжид түшиглэх.	• Шаардлагатай агуулгуудыг багтаасан сургалтын хөтөлбөрийн тоо	ЦХИХХЯ, И-Монгол академи, БЯ
3.2	Сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулах	• 5 зорилтот бүлгийн 40 иргэдийг сургалтад хамруулах.	• Сургалтанд оролцсон иргэдийн тоо • Гүнзгий мэдлэг, ойлголттой болсон иргэдийн тоо • Сургалтыг хэрэгцээтэй гэж үнэлсэн иргэдийн хувь	ЦХИХХЯ, И-Монгол академи, БЯ
3.3	Зорилтот бүлгийн иргэдэд видео клип, дүрсэнд зориулсан alt text хийх зэрэг сургалт зохион байгуулах	• 5 зорилтот бүлгийн 40 иргэдийг сургалтад хамруулах. • 5 видео клип хийх.	• Сургалтад оролцогчдын бэлтгэсэн видео клипийн тоо	ЦХИХХЯ, И-Монгол академи, БЯ
3.4	Зорилтот бүлгийн иргэдийн дунд цахим шилжилтэнд хэрхэн оролцож байгаа талаар өөрсдийн жишээ (стори) бичих уралдаан зохион байгуулах	• 5 зорилтот бүлгийн 10 иргэдийг шалгаруулах. • 40 иргэдийн оролцуулах. (Call for case studies хэлбэрээр зохион байгуулж болно)	• Кэйс / түүхийн тоо • Тухайн түүхүүдийг олон төрлийн сувгуудаар олон нийтэд хүргэсэн тоо	ЦХИХХЯ, И-Монгол академи, БЯ
3.5	Зорилтот бүлгийн иргэдэд кибер аюулгүй байдал, цахим орчинд аюулгүй байх талын сургалт зохион байгуулах	• 40 иргэдийг сургалтад хамруулж, сургагч багшаар бэлтгэх. Сургалт нь онлайн скам, кибер аюулыг хэрхэн таних, сэргийлэх, хамгаалах асуудлыг хамруулна. • 3-4 гарын авлага, зөвлөмж боловсруулах.	• Оролцогчдын тоо • Ур чадвараа сайжруулсан оролцогчдын тоо • Сургалтаас олсон мэдлэгийг практик дээр ашигласан оролцогчдын тоо	ЦХИХХЯ, И-Монгол академи, БЯ

4	ДЭМЖИХ ЧИГЛЭЛ: СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ			
4.1	Зорилтот бүлгийг төлөөлсөн ИНБ-ын оролцоотой боловсруулах бодлого, хууль эрх зүйн баримт бичгийн талаарх мэдээллийг ИНБ-ын вэб портал, мэйлийн лист болон хэвлэл мэдээллээр түгээх	•3-5 мэдээ, мэдээллийг портал сайт, мэйлийн лист болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх	•Олон төрлийн сувгуудаар ИНБ-д хуваалцсан мэдээлэл болон шинэчлэлтүүдийн тоо •Хуваалцсан мэдээлэл болон түүний хэрэгцээт байдалд сэтгэл хангалуун байгаа ИНБ-ын хувь	ОУБ
4.2	Хууль эрх зүй, бодлоготой холбоотой бодлогын товч танилцуулга боловсруулах (жишээ нь хууль тогтоомжийн тухай хууль, цахим багц хууль, г.м.)	•3-5 бодлогын хураангуй боловсруулах.	•Боловсруулсан бодлогын шинжилгээний тоо •Бодлогын хураангуйг ашигласан ИНБ-ын тоо	ОУБ
4.3	Зорилтот бүлгийн иргэдийг цахим шилжилтийн бодлого боловсруулах явцад оролцсоныг илэрхийлсэн видео клип хийх	•5 зорилтот бүлгийн төлөөллийг хамруулсан 5 видео клип хийх. •Олон нийтийн дунд зорилтот бүлгийн иргэдийг цахим шилжилтийн бодлого боловсруулах явцад оролцсон талаар мэдээлэлтэй болгох.	•Бүтээсэн видео бичлэгүүдийн тоо •Видео бичлэгүүдийг үзсэн тоо •Видео бичлэгүүдийг хуваалцсан удаа, мэдээллийн хэрэгслүүдэд нийтэлсэн мэдээ, шинэчлэлтүүдийн тоо •Видео бичлэгүүдийг хэрэгцээтэй, мэдээлэлтэй гэж үнэлсэн олон нийтийн хувь	ОУБ
4.4	Видео клипийг олон нийтийн сүлжээ, ИНБ-ын портал сайт, youtube дээр байршуулах, хэвлэл мэдээллээр сурталчлах			
5	ДЭМЖИХ ЧИГЛЭЛ: ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ			
5.1	Вэб порталд үйл ажиллагааны мэдээлэл, календарчилсан төлөвлөгөө, тайланг оруулах	•Сард 2-3 мэдээлэл оруулах.	•Сар бүр нийтэлсэн мэдээллийн тоо •Нийтэлсэн мэдээллийг хэрэгцээтэй гэж үнэлсэн ИНБ-уудын хувь	ИНБ
5.2	ИНБ-уудад мэйлээр мэдээ, мэдээлэл, зар хүргэх	•Сард 2-3 удаа мэйл явуулах.	•Сар бүр илгээсэн имэйлийн тоо •Илгээсэн имэйлийг хэрэгцээтэй гэж үнэлсэн ИНБ-уудын хувь	ИНБ
5.3	ИНБ-ын вэб порталд ИНБ-ын бүртгэл мэдээлэл оруулах, байнга шинэчилж байх	•ИНБ-ын оруулах мэдээллийн хүснэгтийг баталгаажуулах •40 ИНБ-ын мэдээллийг бүрэн оруулах.	•Баталгаажуулсан мэдээллийн хүснэгтийн тоо •Мэдээллийг нь бүрэн оруулсан ИНБ-ын тоо	ИНБ
5.4	Тайлангийн хурлыг улирал тутам хийх	•Тайлангийн хурал тогтмол зохион байгуулах •40 ИНБ-ыг хурлуудад хамруулах.	•Тайлагналын хуралдааны тоо •Бүх хуралд оролцсон ИНБ-ын тоо •Хурлыг хэрэгцээтэй гэж үнэлсэн оролцогч ИНБ-ын хувь	ИНБ

5.5	Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүдийг хэмжих нэгжийн дагуу боловсруулах	Дараах үзүүлэлтийг хамруулна. Хэмжих нэгж нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ. 1.Зорилго, зорилтын дагуу хийгдсэн арга хэмжээ 2.Зохион байгуулсан арга хэмжээ, тоо, хамрагдсан ИНБ төлөөлөл, ирүүлсэн санал, 3.Сургалтад хамрагдсан иргэдийн тоо, үнэлгээний үр дүн, 4.Зорилтот бүлгийн иргэдийн үр чадварыг дээшилснийг илэрхийлсэн үзүүлэлт 5.Зорилтот бүлгийн ИНБ болон иргэдэд түгээсэн тусгай тоног төхөөрөмж ашигласан байдал (бүртгэл, ашиглалтын зориулалт, г.м.)	• Боловсруулж эцэслэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд	Гэрээт байгууллага
5.6	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын төлөвлөгөө боловсруулах. Төлөвлөгөө нь дараах асуудлыг тусгасан байна. Үүнд: 1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал (түүвэрчилсэн байдлаар зохион байгуулах, асуулга боловсруулж ашиглах, ярилцлага хийх, онлайнаар эсвэл биечлэн зохион байгуулах, нийслэл хот эсвэл хөдөө орон нутгийн ИНБ оролцуулах, зорилтот бүлгийн иргэдэд чиглэгдсэн эсэх, г.м.) 2.Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулах хэлбэр (гэрээт байгууллагаар гүйцэтгэх) 3.Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын төсөв, хэрэгжүүлэх хугацаа, давтамж, 4.Тайлан боловсруулах хэлбэр (үзүүлэн бэлтгэх, кейс хийх түүний талаар видео хийх, брошюр, г.м.)	• Боловсруулж эцэслэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө • Төлөвлөгөөний хэрэгжилт	Гэрээт байгууллага
5.7	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг зорилтот бүлгийн ИНБ-д болон төрийн байгууллагын төлөөлөлд танилцуулах	• Үр дүнг танилцуулсан семинар зохион байгуулах • Үр дүнг илэрхийлсэн тодорхой үзүүлэн боловсруулах (видео, ярилцлагын хураангуй, презентейшн файл, г.м.)	• Семинарт хамрагдсан ИНБ, иргэдийн тоо • Үр дүнг харуулсан боловсруулсан үзүүлэн, материалын тоо	гэрээт байгууллага, ИНБ

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Монгол улс дахь цахим шилжилттэй холбоотой Олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээллийг доорх хүснэгтэд жагсаан харуулав.

Хүснэгт 5. Цахим шилжилтийн хүрээнд ОУБ-уудын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд

#	Хэрэгжүүлэгч	Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөв, санхүүжүүлэлт	Төсөл, хөтөлбөрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл
1.	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	“Accelerator lab” хөтөлбөр.	2020.05.29-өөс 2025.12.31.	150,000 ам.доллар ХБНГУ-ын Засгийн газрын 407,752 ам.доллар	НҮБ-ын 91 оронд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр. Төрийн үйлчилгээнд хийгдэж буй дижитал шилжилтийг тэргүүлэх сорилт хэмээн авч үзэж буй бөгөөд илүү оролцоотой, инновацлаг шийдлийг бий болгохоор түншүүдтэйгээ хамтран ажиллах юм.
2.	Европын Холбоо	Иргэний нийгмийн байгууллагыг (ИНБ) цахим тэгш оролцоог нэмэгдүүлэх нь (DICE) төсөл	2023.12.01-ээс 2026.06.01	670,000 Евро	ПИН ба Фаро Фаундэйшн ТББ-ууд хамтран (I) ИНБ-уудын цахим үр чадварыг сайжруулах, (II) зорилтот бүлгийн цахим болон мэдээллийн үр чадвар ба цахим үйлчилгээнд хандах боломжийг нэмэгдүүлэх, цахим технологийг ашиглан иргэдийн дуу хоолойг өргөх, ба (III) иргэдийн цахим шилжилтийн оролцоог нэмэгдүүлэх зохицуулалтыг дэмжих чиглэлээр ажиллаж эхлээд байна.
3.	Азийн Хөгжлийн Банк	“Электрон засаг ба цахим шилжилт”	2022.12 сараас 2025.12 сар хүртэл	1 сая ам.доллар	Техникийн туслалцааны төсөл нь 1) цахим засаглалын үр өгөөжийг дээшлүүлэх, 2) кибер аюулгүй байдлыг сайжруулах, 3) төрийн үйлчилгээ цахимжиж, төрийн бүтээмж дээшилнэ.
4.	Дэлхийн Банк	Ухаалаг засаг – 2 төсөл	2022.06.06-аас 2027.06.30	41.7 сая ам.доллар (үүнээс 1 сая ам.доллар – Монгол улсын Засгийн газрын дэмжлэг)	Энэхүү төслийн “Төслийн хөгжлийн зорилго” нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх төрийн цахим үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, дижитал үр чадвар, дижитал технологи бүхий ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. Төслийн бүрдэл хэсгүүд: 1. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх 2. Дижитал засгийн шилжилт 3. Дижитал эдийн засгийг хөгжүүлэх 4. Төслийн удирдлага, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх бүрдлийн хүрээнд “Иргэдийн цахим оролцоог хөхиүлэн дэмжих” ажил байгаа.
5.	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг	Иргэдийн оролцоо, мэдээллийн хүртээмжтэй байдлыг дэмжих шинэ хөтөлбөр	2023-2027 он	10 сая ам.доллар, Азийн сантай хамтарсан.	Хөтөлбөр нь мэргэжлийн, хараат бус хэвлэл мэдээллийн болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотой Монголын ардчилсан тогтолцоог улам бэхжүүлж, уян хатан болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэх болно.
6.		Хөгжилтэй, аюулгүй, тэсвэр хатуужилтай Монгол Улсыг дэмжих	2025-2030 он	13 сая ам.доллар	Цэвэр эрчим хүчийн хүртээмжийг дээшлүүлэх, эдийн засгийн ангилалыг нэмэгдүүлэх, ардчилсан институцийг чадваржуулах, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран бизнесийн орчинг сайжруулах, өрсөлдөөнийг